


Багануур Үйлдвэрлэл технологийн парк
ОНӨТҮГ-ын 2023 оны 04 сарын 14-ний
өдрийн 50 дугаартай албан бичгийн
хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

2023 оны 04 дүгээр сарын 14

Багануур дүүрэг

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | хэрэгжилт | хувь |
|--|---|-----------------|---|-------------------------------|-----------------|---|------|
| Стратегийн төлөвлөгөөний зорилго1. Эдийн засгийн зорилтот түвшинг бүрэн хангаж дэд бүтэц инженерийн шугам сүлжээг байгуулна. БҮТП ОНӨТҮГ-ын СТ-2.1, НСТ-3.2 | | | | | | | |
| Зорилт 1.Батлагдсан зураг төслийн дагуу дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд шаардлагатай санхүүжилтыг үе шаттайгаар шийдвэрлүүлнэ. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.2, НХТ-2.2.4 | | | | | | | |
| 1.1 | Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн үндсэн 110/35/10 квт-ын дэд станцын хөрөнгө оруулалтын асуудлыг салбарын яам болон хувийн хэвшлийн байгууллагад танилцуулах | 9911.5 | <ul style="list-style-type: none"> ➢ Улс, нийслэлийн төсөвт хугацаанд нь санал хүргүүлэх ➢ Төр хувийн хэвшлийн түншлэлээр хөрөнгө оруулалтын санал боловсруулах | Иж бүрэн зураг төсөл хийгдсэн | 100 | <ul style="list-style-type: none"> ➢ Дэд станцын хөрөнгө оруулалтын төслийг хувийн хэвшлийн Мөсөс ХХК, Энх өглөө ХХК-д тус тус хүргүүлсэн. ➢ Улс нийслэлийн 2024 оны төсөвт санал хүргүүлэх баримт материалыг бүрдүүлсэн. | 80% |
| Зорилт 2.Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг үе шаттайгаар байгуулна. НХТ-2.2.4 | | | | | | | |

| | | | | | | | |
|-----|---|-------|----------------------|----|-----|---|----|
| 2.1 | Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кв-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах 6,76км урт агаарын шугамыг барих ажлыг үргэлжлүүлнэ. | 400,0 | Ажлын гүйцэтгэл хувь | 30 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ 2023 оны Нийслэлийн төсвөөс батлагдсан 400 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлуудын төлөвлөгөөг Гүйцэтгэгч “Энх-өглөө” ХХК-ийн зүгээс гарган Нийслэлийн хөрөнгө оруулалтын газартай зөвшилцөж, бэлтгэл ажил хийгдэж байна. ➤ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч “Месес” ХХК-тай хамтран 6,76 км агаарын шугамын ажлыг тайлант онд бүрэн дуусгах төлөвлөгөө боловсруулан, бэлтгэл ажлыг хангаж байна. Тус компаниас нийтдээ 1748,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ. | 30 |
|-----|---|-------|----------------------|----|-----|---|----|

Зорилт 3.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн бодлогын баримт бичгийг салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд дэвшүүлсэн төр засгийн бодлого шийдвэр, парктай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акт, дүрмээр тогтоосон чиг үүрэгтэй уялдуулах, чиг үүргийг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах, зохицуулах, зохион байгуулах, боловсон хүчнийг бүрдүүлэх, чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллана.

| | | | | | | | |
|-----|--|---|----------------------|--|---|---|-----|
| 3.1 | 2022 онд УИХ-аар батлагдсан Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын хүрээнд БҮТП-ийн хуулийн этгээдийн хэлбэрийг хуульд нийцүүлэн шинэчлэх, тусгай зөвшөөрөл шинээр авах | - | Тусгай зөвшөөрөл тоо | УУХҮЯ-наас 2022 оны 10 сарын 28 ны өдөр 01/2823 дугаартай зөвлөмж гарч НИТХ, НЗДТГ болон БҮТП-д хүргүүлсэн. Паркуудын болон яамдын төлөөлөл оролцуулсан ажлын хэсэг байгуулах тухай саналыг 2022 оны 10 сарын 17-ны өдрийн 157 тоот албан бичгээр НЗДТГ-т илгээсэн | 1 | <ul style="list-style-type: none"> ➤ Нийслэлийн Засаг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/76 дугаартай захирамжийн дагуу Үйлдвэрлэл, технологийн паркуудын хуулийн этгээдийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулах, дүрмийг шинэчлэн боловсруулах Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Паркийн дүрмийг урьдчилсан байдлаар боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. | 30% |
|-----|--|---|----------------------|--|---|---|-----|

| | | | | | | | |
|-----|--|---|---------------------------------|------|-----|--|------|
| 3.2 | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, дээд газраас ирсэн тогтоол шийдвэр, захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг нэгтгэх, холбогдох дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 99.8 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Бодлогын баримт бичгийн хүрээнд Дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлүүлэхээр Улс, нийслэлийн төсөвт тусгуулах саналыг тогтмол хүргүүлж байна. ➤ Паркийн эрчим хүчний дэд бүтцийг байгуулах, ирээдүйд хэрэгжих аж үйлдвэрийн төслүүдэд шаардлагатай хүчин чадлыг бий болгох, хөрөнгө оруулагч нарт үнэн бодит мэдээлэл хүргэх зорилгоор 01 дүгээр улиралд ЭХЯ болон ЦДҮС ТӨХК-д албан бичиг хүргүүлэн, биечлэн уулзалтууд зохион байгуулсан. ➤ Үүний үр дүнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВ-ын 6,76 км агаарын шугамыг барих ажлыг 2023 онд дуусгах, 2024 оноос өндөр хэрэглээтэй төслүүдэд ТЭЗҮ боловсруулах мэдээллийн санг бүрдүүлсэн. ➤ Дэд бүтцийн бүтээн байгуулалтанд хөрөнгө оруулалтыг өөрсдийн хөрөнгөөр шийдвэрлэх замаар төсөл хэрэгжүүлэх саналуудыг гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарт хүргүүлэн ажилласнаар зарим боломжтой саналуудыг хүлээн авч байна. Тухайлбал Казахстан Улсын өндөр технологи бүхий хүнд үйлдвэрийн төслийн саналыг НЗД-ын орлогч Ж.Сандагсүрэн даргад танилцуулан, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Ерөнхий сайдын ажлын алба, Эдийн засгийн хөгжлийн яамтай нийт 5 удаа | 100% |
|-----|--|---|---------------------------------|------|-----|--|------|

| | | | | | | | |
|-----|--|--|---------------------------------|-----|-----|--|------|
| | | | | | | <p>уулзалт зохион байгуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Нийслэл, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт зэрэгт тусгагдсан холбогдох арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж, тайлагнасан. ➤ 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар ERF системээр дээд газрын 18 тогтоол шийдвэрийн биелэлт, Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 32 үүрэг даалгавар, дүүргийн ЗДТГ-ын 12 үүрэг даалгаврын буюу нийт 62 тогтоол, шийдвэр, захирамж, үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд нь бүрэн хангаж, тайлагнаад байна. | |
| 3.3 | Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангуулах | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <p>2023 он гарсаар Паркийн албан хаагчдыг Нийслэл, дүүргийн ЗДТГ-аас зохион байгуулж буй цахим болон танхимын сургалтуудад чиг үүргийн дагуу оролцуулж байна. 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар давхардсан тоогоор 10 удаагийн сургалтад давхардсан тоогоор 28 албан хаагч хамрагдаад байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - хөрөнгө орлогын мэдүүлэг өгөх сургалт, | 100% |

| | | | | | | | |
|-----|---|-------|---------------------------------|-----|-----|---|------|
| | | | | | | <ul style="list-style-type: none"> - гүйцэтгэл, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, - “Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх аян”-ы хүрээнд аяллын боловсрол олгох, зөв аялах дадлыг бий болгох сургалт, - “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” богино хугацааны сургалт, - Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих цахим сургалт. - “Худалдан авах ажиллагааны хуулийн тухай” сургалт танхимаар зохион байгуулагдах - Цалин, санхүүгийн шинэ программын сургалт - Хүний нөөцийн сургалт зэрэгт хамрагдаад байна. <p>Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд байгууллагын төлөвлөгөөг 4 зорилт 17 арга хэмжээтэйгээр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> | |
| 3.4 | Нийслэлийн төсвөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ 2023 оны Нийслэлийн төсвөөс батлагдсан 400 сая төгрөгийн санхүүжилтийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлуудын төлөвлөгөөг Гүйцэтгэгч “Энх-Өглөө” ХХК-ийн зүгээс гарган НХОГ-тай зөвшилцөж, бэлтгэл ажил хийгдэж байна. ➤ Хөрөнгө оруулалт болон ажлын гүйцэтгэлийн талаар байгууллагын цахим хуудсанд байршуулан, олон нийтэд хүргэх ил тод байдлыг хангасан. | 100% |
| 3.5 | Байгууллагын батлагдсан төсвийг | 317,9 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, | 100% |

| | | | | | | | |
|-----|--|---|---------------------------------|-----|-----|--|------|
| | зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах | | | | | төсвийн хэмнэлтийн тухай хууль болон Засгийн газрын 43 дугаар тогтоол бусад холбогдох журам зөвлөмжийг удирдлага болгон хэрэгжүүлж ажилласнаар 01 дүгээр улирлын байдлаар 2,8 сая төгрөгийн хэмнэлт үүсгэж, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж байна. | |
| 3.6 | “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар намрын улиралд мод тарих | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Тэрбум мод хөтөлбөрт зориулсан ажилтнуудын дундын хуримтлалтай болсон. ➤ Цаг улирлын байдлаар бэлтгэл ажлаа бүрэн хангасан | 100% |
| 3.7 | Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Тус хуулийн холбогдох зүйл заалтын хүрээнд нутгийн захиргааны бүх шатны байгууллага болон дээд шатны байгууллагаас зохион байгуулж буй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, аянд нэгдэн оролцож байна. Тухайлбал: “Хайртай хүмүүсийнхээ төлөө Хором бүрийг АНЗААРЪЯ” аянд нэгдэн оролцлоо. ➤ Хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогыг баримтлан эрх зүйн үндэслэлийг хуульд нийцүүлэн гаргаж байна. <p>Байгууллагын хэмжээнд ямар нэгэн гэмт хэргийн зөрчилгүй ажиллаж байна.</p> | 100% |
| 3.8 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль Хөдөлмөрийн | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Монгол Улсын Засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос Швейцарын хөгжлийн агентлаг, | |

| | | | | | | | |
|---|--|---|---|---|-------------------|---|------|
| | авулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | | | | | <p>НҮБ-ын Хүн амын сангийн "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь" төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээний "Харилцан хүндэтгэе" нэг сарын аянд байгууллагаараа нэгдэж сарын аяны төлөвлөгөөг гарган баталгаажуулж ажиллав.</p> <p>➤ Тус аяны хүрээнд Багануур дүүргийн "Гэрэлт ирээдүй" МСҮТ-ийн хүүхдүүдэд "Мэндлэх хүндлэх-ёс уламжлал"-ын талаар 40 минутын сургалт хийж байгууллага дээрээ "Албан хаагчдын нөлөөлөл" арга хэмжээг зохион байгууллаа.</p> | 100% |
| Зорилт 4.Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 122 дугаар тогтоолын 2.2, 2.3, 2.10 | | | | | | | |
| 4.1 | ШУТИС, МУИС, ХААИС, Шинэ АУИС, Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг Эрдэм шинжилгээний байгууллагуудын шинэ технологийн судалгааг солилцож хамтран ажиллах | - | Паркад хэрэгжих боломжтой шинэ технологийн судалгааны тоо | 2 | 3 ба түүнээс дээш | <p>➤ ШУТИС-ийн гадаад харилцааны хэлтэстэй хамтран Паркийн эрдэм шинжилгээ, судалгаа, иноваци төвд инженерүүдийн судалж байгаа Ферро-силенц-алюмин (ФСА) төсөлд эрдэмтдийн дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах, ШУТИС-ийн эрдэмтдийн үндэсний технологи бүхий хүнд үйлдвэрийн 2 төслөөр гарааны компанийг Паркийн бүсэд байгуулахаар зөвшилцлийн түвшинд ажиллаж байна.</p> <p>➤ Дээрх зорилтот арга хэмжээний хүрээнд ФСА төслийг Паркад хэрэгжүүлэх ТЭЗҮ-ийг боловсруулах төслийг ШУТИС болон Казахстаны эрдэмтэдтэй</p> | 100% |

| | | | | | | | |
|-----|---|---|---------------------------------|--|-----|--|------|
| | | | | | | хамтран хэрэгжүүлэх зорилт тавьсан. | |
| 4.2 | Паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг үзэсгэлэн, уулзалтуудаар сурталчлан таниулж байгууллагын цахим хуудсаар олон нийтэд түгээх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Паркийн үндсэн нэгж Монхимо ХХК-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг үзэсгэлэн, уулзалтуудаар сурталчлан таниулж байгууллагын цахим хуудсаар олон нийтэд тогтмол танилцуулан ажиллаж байна. ➤ 2023 оны 04 дүгээ сарын 20-нд зохион байгуулагдах Нийслэлийн хөрөнгө оруулалтын форумд өргөн хүрээтэй сурталчлах төлөвлөгөө боловсруулан бэлтгэл ажлыг хангасан. | 100% |
| 4.3 | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, гадна инженерийн шугам сүлжээний 2021 онд батлагдсан зураг төслийн дагуу дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тооцоог нарийвчлан дахин хянах, магадлан хийлгэх саналыг НЗДТГ-т хүргүүлэх, бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын тооцоог өнөөгийн нөхцөл байдалд уялдуулан шинэчлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Томсгосон тооцооллын хүрээнд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг боловсруулсан. | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа ч улс нийслэлийн эдийн засгийн байдал хүндрэлтэй байгаа тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах боломжуудыг сайтар судалж байна. ➤ Мөн хувийн хэвшлүүдэд санал тавьж, хамтран харилцан ашигтай ажиллахын тулд дэд бүтцийн хөрөнгө оруулалтын тооцоог цар тахлын дараахь үеийн эдийн засаг, зах зээлийн төлөв байдалтай уялдуулан нарийвчлан дахин хянах, магадлан хийлгэх шаардлагатай байгаа тул байгууллагын хэмжээнд эхний судалгааг хийсэн. ➤ Дээрх судалгаанд үндэслэн мэргэжлийн байгууллагуудаар магадлан хянуулах саналыг НЗДТГ-т 05 дугаар сард | 80% |

| | | | | | | | |
|--|--|---|---------------------------------|--|---|--|------|
| | | | | | | хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| Зорилт 5 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай хүртээмжтэй хүргэнэ | | | | | | | |
| 5.1 | www.shilendans.mn сайтад байгууллагын санхүүгийн баримт бичгийг агуулга стандартын дагуу байршуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт | Баримт бичгийг шилэн данс сайтад стандартын дагуу байршуулсан. | Шилэн дансны тухай хуулийг мөрдөн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллана. | www.shilendans.mn сайтад байгууллагын санхүүгийн баримт бичиг, аудитын болон шалгалтуудын дүн, бусад холбогдох мэдээллүүдийг агуулга стандартын дагуу байршуулан ажиллаж байна. “Монгол Улс дахь Засаглалыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Шилэн дансны сайт шинэчлэгдэж байгаа бөгөөд энэ нь 2023 оноос хэрэгжиж байна. Үүнтэй холбоотойгоор 2023 он гарсаар нийслэл, дүүргийн санхүүгийн албаны нэгдсэн сургалтад мэргэжилтнүүд 2 удаа хамрагдаад байна. | 100% |
| 5.2 | Албан хэрэг хөтлөлтийн журам стандартын дагуу баримт бичгийг боловсруулж хугацаанд нь шийдвэрлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 99,2 | 100 | <ul style="list-style-type: none"> ➢ Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж байна. Баримт бичгийг стандартын дагуу боловсруулан цаг хугацаанд нь шийдвэрлэдэг. ➢ 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар манай байгууллагад 82 албан бичиг, үүнээс хариутай 36, хариугүй 46 албан бичиг ирснээс Удирдлагад 3, Захиргааны албанд 64, Үйлдвэрлэл технологийн албанд 15 бичиг тус тус хуваарилагдан цаг хугацаандаа шийдвэрлэгдэж байна. Хариутай бичгийн шийдвэрлэлт 98.82, хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног. | 100% |
| 5.3 | Иргэдтэй хийх уулзалтыг биечлэн болон цахимаар зохион байгуулж, иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | <ul style="list-style-type: none"> ➢ Газрын дарга 01 дүгээр улиралд 11 иргэнтэй биечлэн уулзаж, 20 орчим холын дуудлага утсаар хүлээн авч Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Паркийн өнөөгийн байдал, | 100% |

| | | | | | | | |
|-----|---|---|---------------------------------|----|-----|---|------|
| | шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах | | | | | <p>тулгамдсан асуудлууд, төслүүдийн бодит боломжуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, чиглэл зөвлөгөө өгч ажилласан байна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагад хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдол байхгүй. ➤ Няраваас гаргасан цалин нэмэгдүүлэх хүсэлтийг шийдвэрлэн, тушаалаар баталгаажуулсан. Өргөдлийг Өргөдлийн дэд системд оруулан бүртгэсэн. ➤ Ямар нэгэн хүсэлт, өргөдлийг ажлын 1 өдөрт багтаан шийдвэрлэх, хяналтыг тухай өдөрт нь тавих, гүйцэтгэлийг баталгаажуулах зорилттой ажилладаг. | |
| 5,4 | Байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 100 | <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулж, агууллагын баяжилт, шинэчлэлтийг г тогтмол хийн ажиллаж байгаа бөгөөд 2023 он гарсаар дараахь мэдээллийг шинэчлэн оруулаад байна. Үүнд: цаг үеийн мэдээллүүд болон хөрөнгө оруулалт, түүний гүйцэтгэл, нийтийн зохион байгуулалттай арга хэмжээнүүдийг байршуулан ажиллаж байна. | 100% |

дундаж хэрэгжилт 90 %

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ ДАВАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.МӨНХТОГТОХ